МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 25

ТӨР, НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХАД ХАМТРАН АЖИЛЛАНА



Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газраас төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад төрийн байгууллагын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, албан хаагчдад хууль, эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр "Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад төрийн байгууллагын оролцоо" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт тус сум дахь Гаалийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын тасаг, Татварын тасаг, Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ зэрэг 25 байгууллагын төлөөлөл, албан хаагчид оролцож төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлын нөхөн төлбөртэй хэрэг маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудал, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр санал солилцож, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар хэлэлцлээ.

Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газраас 2023 онд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар 17 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, 68.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлүүлсэн бол 2024 онд төр, нийтийн ашиг сонирхолд учирсан 127.1 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ

авч ажилласан байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1091